



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/28

Батширээт сум

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,  
техникийн урьдчилсан үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны А/12 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийг 2025 оны 05 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Төрмөнх - Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Л.Ганцогт - Татварын улсын байцаагч
Гишүүд:	Л.Мөнхчулуун - Хурх багийн Засаг дарга
	Б.Бадамгарав - Норовлин багийн Засаг дарга
	Д.Хонгорзул - Онон багийн Засаг дарга
	В.Чулуун - Барх багийн Засаг дарга
	Т.Санчир - Хэсгийн төлөөлөгч, ахлах ахлагч
	Г.Баттулга - Цагдаагийн дэд ахлагч

3. Авто тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийг өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийн бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Техникийн үзлэгийн өмнө авто тээврийн хэрэгслийн албан татвар хураах ажлыг бүрэн барагдуулахыг татварын улсын байцаагч (Л.Ганцогт)-д даалгасугай.

5. Хуваарьт өдөр хэв журам сахиулах, авто тээврийн болон агаарын бохирдлын төлбөрөө төлөөгүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй

байхыг -хэсгийн төлөөлөгч, ахлах ахлагч /Т.Санчир/, цагдаагийн дэд ахлагч /Г.Баттулга/ нарт үүрэг болгосугай.

6. Авто тээврийн хэрэгслийн үзлэгийн үйл ажиллагааны үр дүнг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор танилцуулахыг комиссын дарга (Б.Төрмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ